



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 94

Арвайхээр

Хөрөнгө шийдвэрлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчийн харилцааг зохицуулах журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Есөнзүйл сумын Засаг даргын тамгын газрын балансад бүртгэлтэй хуучин Соёлын төвийн барилгыг “Спортын төв”-ийн зориулалтаар төсөл сонгон шалгаруулж шалгарсан иргэн, аж ахуйн нэгжид шилжүүлсүгэй.

2. Шалгарсан иргэн, аж ахуйн нэгжтэй зориулалтыг өөрчлөхгүй талаар гэрээ байгуулан, хөрөнгийг шилжүүлэх ажлыг зохион байгуулан, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 49 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



А.ИШДОРЖ